

## Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн ХАМТАРСАН МЭДЭЭЛЭЛ

Өмнөговь аймаг  
Ханбогд сум

Иргэдийн хөгжлийн төв  
2016 оны 6-р сарын 06

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн ээлжит хурал 2016 оны 6 дугаар сарын 06-ны өдөр Иргэдийн хөгжлийн төвд боллоо. Хуралд Ханбогд сумын Захиргааны төлөөлөл, Малчидын төлөөлөл, ОТ ХХК-ийн төлөөлөл болон Эрх зүйн нийцэл хяналт, зөвлөгөө, омбудсмений газрын (ЭЗХЗОГ) чиглүүлэгч нар хурлыг чиглүүж зөвлөж ажиллав. Мөн ОТ компаний байгаль орчин, орон нутгийн асуудал хариуцсан ерөнхий менежерүүд болон Ханбогд сумын зарим малчид Зөвлөлийн хуралд ажиглагчаар оролцсон болно.

Тус хурлаар Зөвлөлийн даргын албан үүргийг талуудын тэргүүлэгч гишүүд жил бүр ээлжлэн гүйцэтгэхээр Зөвлөлийн Дүрэмд заасны дагуу Зөвлөлийн даргыг шинээр сонгосон юм. Үүнтэй холбогдуулан, 2015 оны 6 дугаар сард Зөвлөл анхлан зохион байгуулсан цагаас эхлэн өнгөрсөн нэг жилийн хугацаанд Зөвлөлийн даргын үүргийг амжилттай хэрэгжүүлсэн Зөвлөлийн анхны дарга Л.Батцэнгэлд Зөвлөлийн бүх гишүүдээс талархал дэвшүүллээ. Дараагийн нэг жилийн хугацаанд ОТ компанийн төлөөллийн тэргүүлэгч гишүүн О.Цэрэннадмид Зөвлөлийн даргаар ажиллах болов. Мөн Ханбогд сумын Номгон багийн малчдыг төлөөлөн Мягмар ажиллах болсноор Зөвлөл дэх Малчдын төлөөлөл зургаан гишүүнтэй боллоо.

2016 оны 2 сараас эхлэн Ханбогд сумын малчин өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа, Ундай голын гольдрол өөрчлөлтийн улмаас үүссэн хам нөлөөллийн 2-р шатны судалгаа хэрэгжиж байна. Энэхүү судалгааг хэрэгжүүлж буй Олон талт мэргэжлийн шинжээчдийн баг/Хөндлөнгийн Шинжээчдийн Багийн судалгааны ажлын хоёрдах удаагийн явцын тайланг сонсож санал өгөв.

Өнгөрсөн 5 дугаар сард Зөвлөлөөс Гүний хоолойн цооногийн асуудлаар хоёр удаагийн өргөтгөсөн уулзалтыг Ханбогд сумын малчид болон бусад талуудын оролцоотойгоор зохион байгуулсан. Зөвлөлийн ээлжит хурлаар эдгээр уулзалтын үеэр малчдын дэвшүүлсэн саналууд түүний дотор Гүний хоолойн гоожиж буй цооногийг 2016 онд бөглөх асуудлыг хэлэлцлээ. Мөн Гүний хоолойн хайгуулын цооногуудаас бэлчээрийн усан хангамжийн зориулалтаар ашиглах цооногийг тодруулах ажлын хэсэг байгуулж, ажлын төлөвлөгөө гарган ажиллахаар тохирлоо.

### Ханбогд сумын Гурван талт зөвлөл

#### *Гурван Талт Зөвлөлийн тухай*

Ханбогд сумын Сумын удирдлага, Малчдын төлөөлөгчид болон Оюу толгой компанийн хамтарсан Гурван талт зөвлөл (ГТЗ) нь талуудын маргааныг шийдвэрлэх зорилгоор Харилцан ойлголцлын санамж бичигт зурсны дагуу 2015 оны 6 сарын 8-нд албан ёсоор байгуулагдсан болно. ГТЗ-ийн үйл ажиллагааг Эрх зүйн нийцэл хяналт, зөвлөгөө, омбудсмений газраас (ЭЗХЗОГ) чиглүүлж байна. ЭЗХЗОГ бол Дэлхийн банкны группын Олон улсын санхүүгийн корпорацид чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг хараат бус байгууллага болно.